



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар АН/8

Алтай хот

“Эрүүл нийгмийг эмэгтэйчүүд үлгэрлэнэ”
үйл ажиллагааг зохион байгуулахад
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 11 дүгээр хурлыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдах “Эрүүл нийгмийг эмэгтэйчүүд үлгэрлэнэ” үйл ажиллагааг зохион байгуулахад 4,000,000 (дөрвөн сая) төгрөг зарцуулсугай.

2.Шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР